



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/58

Эрдэнэт

Хариуцлагатай эргүүл, жижүүрийг ажиллуулах тухай¹

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/л/, 29.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх үеэр аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, аж, ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталж, томилсугай.

2.Авто замын ашиглалтын нөхцөл, гүүр, гарц, хот хоорондын болон нийтийн тээврийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Авто тээврийн төв (Г.Ядмаа)-д, нийтийн хэв журам хамгаалах, хяналтын пост, эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу)-т, галын аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар)-т, ус, цахилгаан эрчим хүчний хангамж доголдохоос урьдчилан сэргийлж ажиллахыг Хотын захирагчийн алба (С.Ганцогт), Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК (Л.Эрхбаатар), Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (Г.Баярцогт), Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Хангайн бүсийн салбар (П.Баясгалан), Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК (Д.Бүүвэйбаатар)-д, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Томилогдсон хугацаанд хариуцлагатай ажиллахыг агентлаг, хэлтэс, албадын дарга нарт, тухайн байгууллага дээрээ хариуцлагатай жижүүр томилон ажиллуулахыг Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг дарга болон аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (М.Мөнхбаяр), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Онцгой байдлын газар (Г.Ганбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ

А.ТҮВШИНЖАРГАЛ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

№	Хариуцлагатай эргүүл, жижүүрийн нэрс	Ажил, албан тушаал	Ажиллах өдөр, цаг
1	1. Б.Цэвээнсүрэн	Татварын хэлтсийн дарга	2021.02.12-нд 00.00-12.00
	2. Б.Анар	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга	2021.02.12-нд 12.00-24.00
	3. Б.Эрдэнэхүү	Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа	2021.02.12-нд 00.00-24.00
2	4. С.Ганцогт	Хотын Захирагчийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	2021.02.13-нд 00.00-12.00
	5. Ш.Оюунбаяр	Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн хурандаа	2021.02.13-нд 12.00-24.00
	6. Д.Түмэндэмбэрэл	Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн ахмад Д.Түмэндэмбэрэл	2021.02.13-нд 00.00-24.00
3	7. Д.Дэлгэрбаяр	Биеийн тамир, спортын газрын дарга	2021.02.14-нд 00.00-12.00
	8. О.Ариунгэрэлт	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга	2021.02.14-нд 12.00-24.00
	9. Д.Алтанхуяг	Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч	2021.02.14-нд 00.00-24.00

Тайлбар:Хариуцлагатай эргүүлүүд нь Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Дулааны цахилгаан станц ТӨХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК, Шатахуун түгээх станцууд, банк зэрэг байгууллагуудын харуул хамгаалалт болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шалгасан тухай илтгэх хуудсыг Нутгийн удирдлагын ордны байранд гарч буй хариуцлагатай жижүүр болон зохицуулагчид хүлээлгэн өгнө.